

БАТЛАВ:

“НЬЮ СИТИ ПРИНТ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

/Д.ТӨГСГЭРЭЛ/




2017 оны 03 сарын 30 өдөр

БАТЛАВ:

“ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВ”-ийн дарга

/Б.Нарантуяа/



ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

Дугаар 05/09

Улаанбаатар хот

НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1 Нэг талаас “Нью сити принт” / цаашид гүйцэтгэгч гэх / нөгөө талаас “Эрүүл мэндийн хөгжлийн төв”-ийн / цаашид захиалагч гэх / нар харилцан тохиролцсоны үндсэн дээр хамтран ажиллах гэрээг байгуулав.
- 1.2 Энэхүү гэрээний зорилго нь А4 хэмжээтэй, 320 нүүр, 500 ширхэг ном, А4 хэмжээтэй 80 нүүртэй 500 ширхэг ном хэвлэх ажлыг зохицуулахад оршино.
- 1.3 Дээрх номыг чанарын өндөр түвшинд хэвлэж, захиалагч талд хүлээлгэн өгнө. Ном хэвлэлтийн нийт зардал 5,400,000₮ /таван сая дөрвөн зуун мянган төгрөг/
- 1.4 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 1.5 Хэвлэлийн бүтээгдэхүүний хэвлэх ажлыг тухайн бүрт нь хавсралтаар батална.

ХОЁР. Захиалагчийн эрх үүрэг

- 2.1 Захиалагч тал эх загварын алдааг шалгасны эцэст хэвлэх зөвшөөрөл олгон гарын үсэг зурж баталгаажуулна.
- 2.2 Захиалагч тал баталсан эх загвар дээрх алдааг бүрэн хариуцна.
- 2.3 Захиалгат ажлыг гүйцэтгэх явцад захиалагчийн зүгээс хянах, зөвлөх үүрэг хариуцлага бүхий хүнийг ажиллууна.
- 2.4 Гэрээнд тусгагдсан хугацаанд төлбөрийг хийж гүйцэтгэнэ.
- 2.5 Хэрэв захиалагчаас үүдэлтэй шалтгаанаар бүтээгдэхүүнийг ажлын бус цагаар хүлээн авах шаардлагатай болсон бол захиалагч өөрсдийн унаагаар очиж авна.

ГУРАВ. Гүйцэтгэгчийн үүрэг

- 3.1 Гүйцэтгэгч тал Захиалагч талыг эх загвараа баталгаажуулж гарын үсэг зурсны дараа баталсан загварын дагуу чанарын өндөр түвшинд хэвлэнэ.
- 3.2 Захиалгат ажлыг тогтоосон хугацаанд бэлэн болгож, ажлын цагаар хүргэж өгнө.
- 3.3 Гэрээнд заагдсан тооноос илүү хэвлэх, захиалагчтай тохиролцоогүйгээр дахин хэвлэхийг хориглоно.
- 3.4 Захиалагчийн баталсан загвар нь алдаатай байсан өөрөөр хэлбэл захиалагчаас шалтгаалсан нь хэвлэгдсэний дараа илэрсэн тохиолдолд үүнээс үүдэн гарах хохиролыг гүйцэтгэгч хариуцахгүй.
- 3.5 Гүйцэтгэлийн явцад захиалагчийн баталсан загвар дээр байхгүй шинээр нэмж алдаа гаргасан нь тогтоогдсон тохиолдолд гүйцэтгэгч хариуцна.

- 3.6 Бэлэн болох хугацааг загвар баталснаас хойш бүтээгдэхүүний онцлогийг харгалзан тогтоосон хугацаанд бэлэн болгон.
- 3.7 Гүйцэтгэгч нь захиалсан хэвлэмэл бүтээгдэхүүнийг тохиролцсон хугацаа, захиалсан өгөгдөл, тоо ширхэгийн дагуу захиалагч талд хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 3.8 Гүйцэтгэсэн ажлыг актаар хүлээлцэх үед гүйцэтгэгчийн буруугаас үүссэн аливаа гологдол, доголдлыг 5 хоногийн дотор өөрийн зардлаар дахин хийж гүйцэтгэнэ.
- 3.9 Гүйцэтгэгч нь гэрээ байгуулсан захиалагчыг ямар нэгэн хүндрэл чирэгдэл үүсгэхгүйгээр үйлчлэх үүрэгтэй бөгөөд оргил ачааллын үед компанийн хүрээнд аль болох хурдан шуурхай зохицуулах үүрэг хүлээнэ.

ДӨРӨВ. Талуудын хариуцлага

- 4.1 Гүйцэтгэгч тал хэвлэлийн чанарын гологдол гаргасан тохиолдолд захиалагч талыг хохиролгүй болгоно.

ТАВ. Төлбөр тооцоо

- 5 Гэрээгээр гүйцэтгэх ажлын нийт хөлс 5,400,000₮ /таван сая дөрвөн зуун мянган төгрөг/-ийг нэхэмжлэхийн дагуу "Төрийн банк" 109500002389 тоот дансанд тооцоог шилжүүлсэнээр хэвлэлийг хийж гүйцэтгэнэ.

ЗУРГАА. Бусад зүйл

- 6.1 Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчинтэй болох бөгөөд энэхүү гэрээний салшгүй хэсэг нь байна.
- 6.2 Талууд энэхүү гэрээгээр тодорхойлсон үүргээ гүйцэтгээгүйгээс нөгөө талдаа учирсан хохиролыг бүрэн хариуцаж, арилгана.
- 6.3 Гэрээний явцад гарсан маргаантай асуудлыг хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэх ба тохиролцохгүй тохиолдолд хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.
- 6.4 Энэхүү гэрээг 2% үйлдэх бөгөөд тус бүр хүчин төгөлдөр болно.

Гэрээ байгуулсан

ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛ:

"НЬЮ СИТИ ПРИНТ" ХХК-ийн
Ерөнхий менежер.


/П.Бат-Өлзий/

Хаяг: Улаанбаатар Баянзүрх, 6-р хороо, "Шинэ-Од" трейд байр /69-1 тоот/

Утас: 99758888, 99529212

ЗАХИАЛАГЧ ТАЛ:

"ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВ"-ийн Ерөнхий нягтлан


/Б.Гантуяа/

Хаяг: Улаанбаатар хот-46
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15

Утас: 99106207,